

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 6 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 9 цаг 00 минутад эхэлж, 9 цаг 47 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 47 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	"Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13, 35 дугаар зүйлийн 35.1.3, "Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3 дахь хэсгийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын "Нэг"-ийн 1.3, 1.4, "Хоёр"-ын 2.3.1, 2.3.4, 2.4, 2.4.1, 2.4.3, 2.4.4, 2.4.5-д тус тус дор дурдсан өөрчлөлт оруулах:</p> <p>Журмын 1.3 дахь хэсгийг:</p> <p>"1.3. Яам, аймаг, нийслэл орон тооны бус Салбар зөвлөлтэй байна. Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, агентлагт орон тооны бус Салбар зөвлөл ажиллуулах асуудлыг тухайн салбарын болон байгууллагын төрийн албан хаагчдын тоо, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хамрах хүрээ, агентлагийн хувьд холбогдох яамны дэргэдэх Салбар зөвлөлийн саналыг харгалзан Төрийн албаны зөвлөл шийдвэрлэнэ. Салбар зөвлөлгүй</p>

		<p>агентлагт түүний эрх, үүргийг чиглэлийн яамны дэргэдэх Салбар зөвлөл хариуцах бөгөөд түүний бүрэлдэхүүнд уг агентлагийн төлөөллийг оролцуулна." гэж;</p> <p>Журмын 1.4 дэх хэсгийг: "1.4."Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3-т заасан ёсоор Төрийн албаны зөвлөл Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилно. Яаманд Төрийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлд Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга, Үндэсний статистикийн хороонд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагт агентлагийн дарга, аймаг, нийслэлд Засаг даргын Тамгын газрын дарга Салбар зөвлөлийн дарга байна." гэж;/</p> <p>Журмын 2.3.1 дэх заалтыг: "2.3.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын болон Шүүхийн Тамгын газар, хэлтэс, Статистикийн газар, хэлтсийн төрийн захиргааны албан тушаалд анх орох иргэнээс төрийн албаны мэргэшлийн шалгалт авах ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журам, зааврын дагуу зохион байгуулах;" гэж;</p> <p>Журмын 2.3.4 дэх заалтыг: "2.3.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээ (тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй)-ний нутгийн захиргааны байгууллага (цэрэг, цагдаа, гааль, тагнуулын байгууллага, тахарын алба орохгүй), шүүхийн Тамгын газар, хэлтэс болон Статистикийн газар, хэлтэс, орон нутгийн өмчийн төсвийн</p>
--	--	---

		<p>байгууллагын төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдох мэдээ, төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний болон бусад тайлан, судалгааг гаргах;" гэж;</p> <p>Журмын 2.4. дэх хэсгийг: "2.4.Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо болон яам, агентлагийн дэргэдэх Салбар зөвлөл нь дараах тусгай үүргийг хэрэгжүүлнэ:" гэж;</p> <p>Журмын 2.4.1 дэх заалтыг: "2.4.1.Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, яам, агентлагийн төрийн захиргааны, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга (Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хорооны болон яамны газрын даргаас бусад)-ын албан тушаалд томилогдох нэг ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаарх дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий этгээдэд өгөх;" гэж;</p> <p>Журмын 2.4.3 дахь заалтыг: "2.4.3.Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, яам болон агентлагийн дэргэдэх Салбар зөвлөл нь яам, аймаг, нийслэл, дүүрэгт ажилладаг Шүүхийн Тамгын газар, хэлтэс, Статистикийн газар, хэлтэс, мэргэжлийн хяналт, татвар, улсын бүртгэл, нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн салбарын болон тахарын албаны нутгийн захиргааны байгууллагын дарга (төсвийн шууд захирагч)-ын болон тэдгээр байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргын албан тушаалд томилогдох нэг ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журам, Төрийн албаны зөвлөлөөс баталсан зааврын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаарх дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий этгээдэд өгөх." гэж;</p> <p>Журмын 2.4.4 дэх заалтыг:</p>
--	--	--

		<p>"2.4.4.Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, яам, агентлагийн болон аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төвлөрсөн удирдлагатай нутгийн захиргааны байгууллага, Шүүхийн Тамгын газар, хэлтсийн төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг Улсын Их Хурлаас баталсан журамд заасны дагуу хүлээн авч, хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;" гэж;</p> <p>Журмын 2.4.5 дахь заалтыг:</p> <p>"2.4.5.Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Тахарын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл нь агентлаг, тэдгээрийн харъяа байгууллагын төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдох мэдээ, төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний болон бусад тайлан, судалгааг гаргах;" гэж.</p> <p>Хоёрдугаар зүйл. Энэ тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахар тогтов.</p>
2	Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Тахарын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл байгуулах тухай	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3-т заасныг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн</p>

		<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулах.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Салбар зөвлөлийн дарга: Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга</li> <li>• Гишүүд: <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн хүний нөөцийн газрын дарга,</li> <li>- Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга,</li> <li>- Шүүхийн хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга,</li> <li>- Шүүхийн сургалтын албаны дарга,</li> <li>- Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн дарга,</li> </ul> </li> <li>• Нарийн бичгийн дарга: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны хүний нөөц хариуцсан референт</li> </ul> <p>Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3-т заасныг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулах.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах</p>
--	--	--

		<p>бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Салбар зөвлөлийн дарга: Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга</li><li>• Гишүүд:<ul style="list-style-type: none"><li>- Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга,</li><li>- Макро эдийн засгийн статистикийн газрын дарга,</li><li>- Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга,</li><li>- Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга,</li><li>- Мэдээлэл, сургалт сурталчилгааны төвийн дарга,</li></ul></li><li>• Нарийн бичгийн дарга: Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч.</li></ul> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Тахарын ерөнхий газар, Хууль зүйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3-т заасныг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн Тахарын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулах</li><li>2. Төрийн албаны зөвлөлийн Тахарын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. Үүнд:</li></ol> <ul style="list-style-type: none"><li>• Салбар зөвлөлийн дарга: -Тахарын ерөнхий газрын дарга</li><li>• Гишүүд:</li></ul>
--	--	--

		<ul style="list-style-type: none"><li>- Тахарын ерөнхий газрын тэргүүн дэд дарга,</li><li>- Тахарын ерөнхий газрын дэд дарга (Захиргаа, удирдлага хариуцсан),</li><li>- Тахарын ерөнхий газрын дэд дарга (Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан),</li><li>- Тахарын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын дарга,</li><li>- Тахарын ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга,</li><li>- Тахарын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга,</li><li>- Тахарын ерөнхий газрын Дотоод аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга,</li></ul> <p>• Нарийн бичгийн дарга: Тахарын ерөнхий газрын Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 01/174 тоот албан бичгээр ирүүлсэн санал хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны хүний нөөц хариуцсан референт Баярын Пүрэвдагвыг томилох.</li><li>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Пүрэвдагвад даалгах тухай Монгол</li></ol>
--	--	--

		<p>Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Үндэсний статистикийн хорооны 2014 оны 01/126 тоот албан бичгээр ирүүлсэн санал хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Төрийн албаны зөвлөлийн Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Төмөрчөдөр овогтой Гантөмөрийг, нарийн бичгийн даргаар тус хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч Шаравсэнгэ овогтой Оюунгэрэлийг тус тус томилох.</li><li>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Т.Гантөмөр, нарийн бичгийн дарга Ш.Оюунгэрэл нарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li></ol> <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын 2014 оны 27 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Тахарын ерөнхий газрын 2014 оны 01/12 тоот албан бичгээр ирүүлсэн санал хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар</p>
--	--	---



		<p>сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Төрийн албаны зөвлөлийн Тахарын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар Тахарын ерөнхий газрын дарга Цэвээнравдангийн Азбаярыг томиллох.</li><li>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ц.Азбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li></ol>
--	--	--

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ